

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг
зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн арван
тавдугаар хуралдааны тэмдэглэл /2016-12-20/**

Үндэсний зөвлөлийн арван гуравдугаар хуралдаан 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 14 цаг 50 минутад Төрийн ордны “Нутгийн удирдлагын танхим”-д эхлэв.

Хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн дарга Ж.Эрдэнэбат, ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Н.Энхбаяр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, ахлах мэргэжилтэн Д.Дамба, Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа, мэргэжилтэн н.Ариунаа, Монгол улсын ерөнхий аудитор А.Зангадыг орлож, стратег удирдлагын газрын дарга Д.Өлзий, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа, Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирлын зөвлөх М.Буянбадрах, Монголросцветмет ХХК-ийн тэргүүлэх мэргэжилтэн М.Болдбаатар, Монполимет ХХК Группын гүйцэтгэх захирал С.Энхтуяа, Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэлийг орлож, төрийн байгууллагын харилцаа, зөвшөөрөл хариуцсан захирал Б.Сугармаа, Оюутолгой ХХК-ны ерөнхийлөгч Андрию Вүүдлэйг орлож, орон нутгийн харилцаа хариуцсан ерөнхий менежер Ш.Байгалмаа, Нээлттэй нийгэм форумын захирал П.Эрдэнэжаргалыг орлож, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын дарга Л.Долгормааг орлож, гүйцэтгэх захирал Г.Батсайхан, Монголын байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Н.Наранцэцэг, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Ю.Дэлгэрмаа нар оролцов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 30 гишүүдээс 18 гишүүд оролцож ирц 60 хувьтай байв.

Мөн хуралдаанд Улаанбаатар аудит корпораци ХХК-ны захирал Б.Осоргарав, аудитын менежер Н.Эрдэнэцог, ахлах аудитор Б.Дэлгэрмаа, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтэн Г.Оюунтуяа, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн мэргэжилтэн А.Отгонтунгалаг, Мэдээлэл технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн арван тавдугаар хуралдааныг Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат удирдан явуулав.

Ж.Эрдэнэбат: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр миний хувьд анхны хуралдаанд оролцож байна. Үндэсний зөвлөлийн гишүүд ОУИТБС-тай холбоотой асуудал санал бодлоо хуралдааны явцад илэрхийлж, идэвхтэй оролцохыг хүсье.

Хуралдааны журам ёсоор хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулав. Гишүүд хэлэлцэх асуудлыг зөвшөөрч, батласнаар хуралдаан эхлэв.

Ж.Эрдэнэбат: Хөтөлбөрийн дагуу Монгол улсын ОУИТБС-ын 2015 оны буюу 10 дугаар тайлан Улаанбаатар аудит корпорацийн захирал Б.Осоргарав танилцуулна.

1. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны тайлан

Б.Осоргарав: Монгол улсын ОУИТБС-ын 2015 оны тайлан та бүхэнд танилцуулж байна. Бид эхлэлтийн тайланг 2016 оны 8 сарын 11-нд оролцогч талуудад танилцуулсан. Тайлан бэлтгэлийн явц, оролцогч талуудыг оролцуулсан сургалтыг 3 удаа хийж, 138 хүнийг хамруулсан. Бид Англи улсын Лондонд төвтэй Харт Нойрс гэдэг нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг дэлхийн олон оронд үйл ажиллагаа явуулдаг, арвин их туршлагатай байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн. Улаанбаатар аудит корпораци нь Грант Торнтон Интернэйшнл ОУБ-ын Корреспондент гишүүн байгууллага юм.

ОУИТБС-ын 2015 оны тайлан нь танилцуулга, тайлангийн цар хүрээ, тохируулгын хураангуй, гол асуудлууд, зөвлөмж, тайланд тусгагдсан бусад асуудал гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. ОУИТБС-ын 2015 оны тайлангийн тохируулга нэгтгэлд ТӨААН-үүд 10, Засгийн газрын байгууллага 10, Орон нутгийн засаг захиргаа 21 болон компани 192 хамрагдсан. Нэгтгэлийн тохируулгын явцад нэгтгэлд хамрагдахаар сонгогдсон 202 компаниас 8 компани ямар нэгэн байдлаар холбогдох боломжгүй, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаггүй зөвхөн лиценз эзэмшдэг, өөр төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд байсан тул тохируулгын зөрүүгээс хассан байгаа. Тохируулгын өмнө Засгийн газар хүлээн авсан болон компанийн төлсөн татварын тайлагналыг зөрүү нь 303,5 тэрбум төгрөг байсан, улмаар тохируулгын дараа тайлбарлагдаагүй зөрүү нь 112 сая төгрөг хүртэл бууруулсан. Засгийн газар эдгээр 8 компаниас 1,64 тэрбум төгрөг хүлээн авсан гэж тайлагнасан, нэг компани 100 сая төгрөгнөөс дээш татвар төлсөн учраас сонголтод орсон байсан. Засгийн газрын орлогыг 1,39 их наяд төгрөг хүртэл тохируулсан. 2015 онд олборлох салбараас хүлээн авсан Засгийн газрын нийт орлогын 98%-ийг нэгтгэлд хамруулсан. Засгийн газрын бүх байгууллага болон ТӨААН нь орлого, төлбөрөө тайлагнасан, 8 компани цахим тайлагналын системд тайлангаа шивээгүй, мөн бидний явуулсан маягтын дагуу тайлангаа ирүүлээгүй. Засгийн газрын 4 байгууллагаас бусад нь удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй учраас Засгийн газрын тайланд баталгаа байхгүй байна. Бүх ТӨААН-үүдээс нэгээс бусад нь удирдлагын хариуцлагын захидлыг ирүүлсэн, 5 байгууллага аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй. Топ 10 компаниуд бүгд өөрсдийн тоон мэдээллээ баталгаажуулсан удирдлагын хариуцлагын тайлангаа ирүүлсэн, 2 компани аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байна. 2015 онд Бүтээгдхүүн хуваах гэрээ хийгдсэн боловч олон нийтэд ил тод болоогүй, 2015 онд лицензийн өөрчлөлтийн мэдээллүүд хоорондоо зөрүүтэй байна. 2014 оны тайланд нийт 11 зөвлөмж өгснөөс 7 зөвлөмж хэрэгжиж байгаа, 4 зөвлөмж хэрэгжээгүй байна. Тухайлбал, төслийн хүрээний тайлагнал, Засгийн зардын тайлагнасан мэдээллийн баталгаажуулалт ТӨААН-ийн мэдээллийн ил тод байдал, кадастрын мэдээлэл зэрэг зөвлөмжүүд хэрэгжээгүй байна. (Танилцуулгыг хавсаргав)

Ж.Эрдэнэбат: Тайлангийн танилцуулгыг хийсэн компанийн төлөөлөлд баярлалаа. Гишүүдээс тайлантай холбоотой асуулт байна уу?

Д.Эрдэнэчимэг: Нэгтгэлийн явцад нэгтгэлд орсон 8 компанийг холбогдоогүй, мэдээлэл тодруулга авч чадаагүй учраас зөрүүг тохируулахад хассан гэж байна. Үүнийг ямар шалгуураар сонгож авсан бэ? Эдгээр компаниуд нь түүвэрлэж сонгож

авсан компаниудаас гарсан уу, материаллаг босго даваагүй боловч түүвэрт орсон компаниуд гэж ойлгож болох уу?

Н.Эрдэнэцог: Нэгтгэлд хамрагдах 202 компанид эдгээр компаниуд орсон. Холбогдох ямар боломж байгаагүй. Эдгээрийн нийт төлсөн татвар нь 1,6 тэрбум төгрөгийн орлого хүлээн авсан, бүгд 100 саяаас дээш төгрөгийн татвар төлсөн хамгийн их нь 300 сая төгрөгний татвар төлсөн байдаг, гэтэл үндсэн үйл ажиллагаа нь уул уурхай биш, зөвхөн нэг лиценз л эзэмшиж байдаг. Тухайлбал, Увс аймагт шатахуун борлуулдаг компани улсад 90 гаруй тэрбум төгрөгий, татвар төлсөн боловч олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаггүй. Иймэрхүү компаниуд нилээд олон байгаа, стандартаар авч үзэхэд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг байх ёстой гэдэг. Иймээс нэгтгэлийн тохируулга хийхэд хассан.

Н.Баярсайхан: Тэр 8 компанийг тодорхой болгомоор байна. Бид төсөл бүрээр нь тайлагнах ёстой, лицензтэй компани нэгтгэлд орох ёстой байх, өөр үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд босгод орсон нь харамсалтай байна. Бид ахиц дэвшил гарч байгаа гэж ойлгож байгаа, эдгээр 8 компани оронд өөр 8 компанийг босгод оруулж, ил тод болгох боломжтой байсан гэж харж байна. Иймээс энэ дээр тодруулга хийчихвэл зүгээр гэсэн саналтай байна. Тайлантай танилцахад гэрээг ил тод болгох асуудал, төрийн өмчит компаниуд тайлангаа ирүүлээгүй, агентлаг хоорондын тоо мэдээ зөрүүтэй байсан гэсэн бидний мэдэх, анхаарал татсан гол асуудлыг дурдсан байна. Энэ нь яагаад зөвлөмж дээрээ байхгүй байна. Зөвлөмжийг харахад аудит хийх үйл явцад тулгамдсан асуудлаа зөвлөмж болгосон мэт харагдаж байна. Иймээс бид зөвлөмжөө яаж харах ёстой вэ, хэдүүлээ нэгдсэн ойлголттой болмоор байна. Зөвлөмжийг аудит хийх үйл явцад хандсан зөвлөмж, ОУИТБС буюу уул уурхайн салбарын засаглалыг сайжруулахад юу хийх талаар зөвлөмжүүд гэх мэт чиглэл чиглэлээр нь салгаж, эрчимжүүлж өгмөөр байна. Иж бүрэн байдал, мэдээллийн баталгаат байдал дээр илүү анхаарсан гэж ярьсан, иж бүрэн байдлаа хангаагүй юм шиг байна. Энэ дээрээ зөвлөмжөө илүү чиглүүлэх санал байна. Агентлаг хоорондын мэдээ зөрүүтэй байгаагаас ОУИТБС-д ирж байгаа мэдээлэл зөрж байгаа гэсэн үг, тэгэхээр үүнийг яаж тохируулах вэ, тайлангаа гаргахгүй байгаа ТӨК-уудыг яаж тайлан гаргуулдаг болгох вэ, гэрээг ил болгох асуудлаар зөндөө ярьсан, одоо яагаад болохгүй байна гэх мэт асуудлуудыг өнөөдрийн хуралдаанаар шийдэл гаргавал илүү ач холбогдолтой болох болов уу.

Б.Осоргарав: Нэгтгэлээс хасагдсан 8 компаниудыг дэлгэрэнгүй танилцуулъя. Анхай интернэйшнл 127 сая төгрөгний татвар төлсөн, лиценз шилжсэн, Блэйк майнинг 320 сая төгрөгний татвар улсад төлсөн, АМГ, ТЕГ гаалийн байгууллагаас утсыг нь авч холбогдох гэсэн боловч чадаагүй, Глакси майнинг татан буугдсан, Ган илч үндсэн үйл ажиллагаа нь уул уурхай биш аймгийн төвийн халаалт хариуцдаг компани гэсэн Энержи Импайр Увсын Улаангомд байдаг, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй, захирлын дүү гэх хүн 1 удаа утас авсан боловч дахиж холбогдоогүй, Эс Эс Жи Пи гэдэг компани ганц утас байсан боловч холбогдоогүй, Эм Кэй Эм майнинг 157 сая төгрөгний татвар төлсөн, утас байхгүй, Гурван богдын нуруу 207 сая төгрөгний татвар төлсөн, лицензээрээ үйл ажиллагаа явуулаагүй гэсэн мэдээлэлтэй, бүх холбогдох баримтууд нь байгаа.

Н.Баярсайхан: Холбогдохгүй байгаа юмуу, олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаггүй юм уу?

Ж.Эрдэнэбат: Аудитын тайлбараар лиценз эзэмшдэг боловч олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаггүй өөр үйл ажиллагаа эрхлэдэг компаниуд юм

байна. цаашдаа ийм компаниудыг яах вэ? ТӨК-уудын нөхөн сэргээлтийн асуудал, ил тодын тайлан гаргадаг болох талаар Үндэсний зөвлөлийн хурлаас гарах шийдвэрт тусгаж, шийдэл гаргах боломжтой.

Өөр санал хэлэх хүн байна уу?

Д.Эрдэнэчимэг: 2014 оны тайлангийн зөвлөмжийн 4 нь хэрэгжээгүй гэж байна. Хэрэгжээгүй зөвлөмжийн 3 нь энэ жилийн тайлангийн зөвлөмжид тусгагдсан байна, нэг огт тусгагдаагүй байна. Үүнийг бас зөвлөмждөө тусгавал зүгээр. Төсөл бүрээр тайлагнах ёстой байгаа. Энэ нь стандартын хүрээнд заавал тайлагнах ёстой асуудал юм. Хэрвээ төслийн түвшинд тайлагнаад ирэхээр лиценз эзэмшдэг ч уул уурхайн үйл ажиллагаа явуулдаггүй гэж яригдаад байгаа асуудал тодорхой ялгагдаж харагдах байсан байх.

Н.Алгаа: Би ОУИТБС-ын тайланг 10 дахь жилдээ сонсож байна. Жилээс жилд сайжирч байгаа, тодорхой ахиц дэвшил гарч байгаа, урьд нь зөвлөмжийг хаядаг байсан бол одоо үнэлдэг болсон байна, хэрэгжсэн хэрэгжээгүйг тогтоодог болсон байна, иж бүрэн байдал дээр том ахиц гарсан байна. Манай улсын онцлог лиценз эзэмшээд өөр үйл ажиллагаа явуулдаг, зарим нь олборлолт явуулалгүй 6,7 жил ч болсон компани ч байдаг. Бусад оронд бүртгэлийн тодорхой зохицуулалт байдаг, лиценз бүрээр нь тусад нь бүртгэдэг системд орохгүй бол болохгүй энэ байдал байнга давтагдах байх, үүнийг салбарын онцлогийг нь харгалзаад өөр жишиг дүрэм мөрдөх шаардлага байна гэж харж байна. Энэ жилийн тайланг Улаанбаатар аудит хийсэн. Олон жил хийж байгаа учраас жилээс жилд сайжирч байна, энэ жилийн тайлан сайн болсон байна. Иймээс тайланг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Н.Баярсайхан: Бид сүүлийн 3 жил ОУИТБС-ийн тайлангийн ашиглалтыг сайжруулах талаар ярьж байгаа. Иймд би өөрөө энэ тайлангаас байгаль орчны нөхөн сэргээлтийн тайланг ашиглаж үзлээ. маш сайн мэдээлэл гарч байна. Байгаль орчны яам нөхөн сэргээлтийн барьцаа дансан дахь мөнгөн хөрөнгийн мэдээллийг гаргадаг, ОУИТБС-ийн цахим тайланд бас энэ мэдээлэл тавигдаж байгаа. Сүүлийн 5 жил нөхөн сэргээлтийн мөнгөө буцааж авсан компани байхгүй гэж Байгаль орчны яам мэдээлж байгаа. Тайлангаас харахад барьцаа хөрөнгө авч байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаа хийгдсэн харагдаж байна. Энэ хоёрын хооронд 20-иод тэрбумын зөрүү байгаа. Уул уурхайн салбарыг муухай харагдуулж байгаа, нийгэм хүлээн авахгүй байгаа нэг асуудал нь нөхөн сэргээлт юм. Үүнээс харахад нөхөн сэргээлт хийхээр дэнчин авч байршуулж байгаа эрх зүйн орчин, нөхөн сэргээлт хийлгэх хариуцлагын тогтолцоо хоёр болохгүй байгааг харуулж байна. Яам агентлагийн хоорондын мэдээллийн зөрүүтэй байдал, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө байршуулчихаад, барьцаа хөрөнгөө компани нь авдаггүй, төр нь өгдөггүй байдал харагдаж байгаа. Энэ талаарх мэдээллийг компани бүрээр нээлттэй авъя гэхээр компаниуд өөрсдийн нууцын зэрэглэлд хамруулах хүсэлтээ БОЯ-нд бичиг өгсөн байна. Гэтэл холбогдох хууль журмыг үзэхээр заавал нээлттэй байх мэдээллийн жагсаалтад байгаад байдаг. Цахим тайлангийн мэдээллийг харахад 32

тэрбум төгрөг одоогийн байдлаар БОАЖЯ-ны тусгай дансанд байхаар харин Байгаль орчны яам ТББ-ын албан бичгийн хариунд өгсөн мэдээллээр 10 тэрбум төгрөг л байгаа гэж байгаа. Энэ зөрүүтэй байдлыг яаж цэгцлэх вэ, мэдээллийн баталгаатай, иж бүрэн байдал байхгүй байх шиг харагдаж байна. Энэ талаар хурлын шийдвэрт тодорхой арга хэмжээ авахаар тусгах санал байна.

Ж.Эрдэнэбат: Хуралдааны шийдвэрт нөхөн сэргээлт, барьцаа хөрөнгийн талаар тусгахаар боллоо. Ингээд нэгдүгээр асуудлаа хаая.

Н.Баярсайхан: Тайлангаас харахад Оюутолгой компани багагүй хэмжээний хандив өгснөөр харагдаж байна. 2014 оны тайланд нийт хандивын 60 хувь нь мөн Өмнөговь аймаг авсан байсан. Энэ нь яахав тодорхой концессийн гэрээгээр баригдсан сургууль цэцэрлэгийн урсгал зардалтай холбоотой байж болох юм. Харин ОТ ХХК-ны үзүүлж байгаа хандив тэр дундаа Говийн оюу сангийн жил бүрийн 5 сая доллар чинь монголын талаас төлөх 34 хувь дээр нэмэгдэж өр болж байгаа юу, компанийн цэвэр ашгаас хийгдэж байгаа юу? үүнийг тайлбарлаж өгнө үү.

Ш.Байгалмаа: Энэ гэрээ Ашигт малтмалын тухай хуулийн 42,1 болон хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр зүйлийн дагуу хийгдсэн. Гэрээнд орон нутагтайгаа гэрээ хийж, сан байгуулж ажиллана гэж тусгасан байдаг. Энэ мөнгө компаниас нийгмийн хариуцлагын дагуу хийсэн ажил юм. Бид өнөөг хүртэл нилээд их хэмжээний хөрөнгө зарцуулсан. Үүнийг эмх цэгцтэй болгох үүднээс орон нутагт эрх мэдлийг чиглүүлээд иргэд өөрсдийн хүсэл зорилгын дагуу орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор сан байгуулж, Оюутолгой санхүүжилтийг олгох чиглэлээр ажиллаж байгаа.

Н.Баярсайхан: Эх үүсвэрийг яг ямар зардлаас гэдгийг асуугаад байна л даа. ОТ ХХК-ны цэвэр ашгаас гэж ойлголоо зөв үү.

Ш.Байгалмаа: Компанийн нийгмийн хариуцлагын зардал хаанаас гардаг юм чи өөрөө хэлээтэх... уурлав.

Ж.Эрдэнэбат: Би Оюутолгой дээр ажилласан. Ер нь нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой хэмжээний хандив дэмжлэгийг үзүүлж байгаа. Энэ тусламж дэмжлэгийн 50-иас доошгүй хувийг ажлын байр бий болгох талаар орон нутаг, компанид чиглэл өгсөн. Компанийн нийгмийн хариуцлагын талаар хийх ажлыг хуульчлаад өгье гэсэн санал байгаа. Тухайлбал, уул уурхай, боловсруулах үйлдвэр, худалдааны компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд юу хийх ёстойг тусгаж, хуулийн төсөл боловсруулах байх.

Ингээд журмын дагуу дараагийн асуудлыг төслийн зохицуулагч Ш.Цолмон танилцуулна.

2. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2017 оны төлөвлөгөөний төсөл, цахим тайлагналын журам, нээлттэй мэдээллийн бодлогын тухай

Ш.Цолмон: 2016 онд нийт 53 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 34 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлтийн хувь 65 байна. Ажлын хэсэг 3 удаа, дэд хэсэг 2 удаа хуралдсан байна. Үндэсний зөвлөл өнөөдөр хуралдаж байна. Нилээд ажлууд хэрэгжүүлж чадаагүй шалтгаан нь Дэлхийн банкины төслийн санхүүжилт, түүний гэрээ бэлтгэх ажил 8 дугаар сарын 20-н хүртэл саатсан байна. Саатсан гол ажлууд орон нутгийн Дэд зөвлөлийг чадавхжуулахтай холбогдсон болон Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулах зэрэг байсан бөгөөд эдгээр ажлуудыг 2017 онд хэрэгжүүлэхээр хойшлуулж, төлөвлөгөөнд оруулсан байна.

Хэрэгжсэн томоохон ажлуудыг дурдвал, 2016 оны 2 дугаар сард Перу улсад зохиогдсон Олон улсын ээлжит бага хурлын үеэр Монгол Улс “мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлснийхээ” төлөө ОУИТБС-ын даргын нэрэмжит шагналыг хүртсэн байна. Монгол Улс хошой шагналтай улс болоод байна. Өмнө нь 2011 онд тайлангаас тайланд хамрах зүйлээ сайжруулан тайлагнаж байгаагийн төлөө мөн шагналыг хүртсэн, 2015 оны ОУИТБС-ын тайлан гаргах аудиторын түншлэлийг сонгон шалгаруулах ажлыг олон маргааныг давж байж, зохион байгуулсан бөгөөд Монголын Улаанбаатар аудит корпорац, Их Британийн Харт Нойрс байгууллагын түншлэл эцэст нь шалгарч, ОУИТБС-ын стандартын дагуу эхлэлийн семинар зохион байгуулж, гэрээт ажлын цар хүрээг эцэслэн тохирч, 202 компанийн тайланг Засгийн газрын тайлантай тулган баталгаажуулж, өнөөдөр дүнг танилцуулж байна. Компани, Засгийн газрын байгууллагуудын 2015 оны тайлагнах ажлыг зохион байгуулж, 747 компани, Төрийн 32 байгууллага 1920 компаниас орлого хүлээн авсан тухай ОУИТБС-ын тайлангаа гаргасан байна. Уул уурхайн ашиг хүртэгч эздийн ил тод байдлын судлах ажлыг зохион байгуулах өргөн бүрэлдэхүүнтэйгээр дэд хэсгийг УУЯ дээр зохион байгуулж, холбогдох уулзалтуудыг зохион байгуулсан. Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэнтэй хамтран сургалт зохион байгуулж, Замын зураг хэмээх төлөвлөгөөг боловсруулан танилцуулж байна. УИХ-ын эдийн засгийн байнгын хороон дээр байгуулагдсан “Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төслийн ажлын хэсэгт 3 удаа хуралдаж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн хэдий ч, УИХ хэлэлцэж чадсангүй. Монгол Улсын ОУИТБС-ын Олон улсын баталгаажуулалтын 2016 оны 7 дугаар сарын эхээр зохион байгуулж, холбогдох тайланг дүнг танилцуулж ирсэн бөгөөд 12 дугаар сард эцсийн дүнг ирүүлнэ.

Орон нутгийн харилцааны ажлыг сайжруулах зорилгоор ЕСБХБ-ны туршилтын төслийг боловсруулах, судалгааг холбогдох байгууллагаар эхлүүлэхээр болоод байна. 2016 оны сонгуулиар дүнгээр шинэчлэгдсэн аймгийн удирдлагуудын уулзалтыг Засаг даргын орлогчийг түвшинд зохион байгуулж, ОУИТБС-ын дэд зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

2017 оны ажлын төлөвлөгөөний төслийг Ажлын хэсэгт 11 дүгээр сарын 18-нд танилцуулж, холбогдох санал зөвлөмжийг авч, дахин боловсруулан танилцуулж байна. 2017 оныг Монгол Улсад ОУИТБС-ын “Дэд зөвлөлийг чадавхжуулах, ашиг хүртэгч эздийг ил болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх” жил болгон ажиллана. Нэгдүгээр зорилгын хүрээнд нийт 21 үйл ажиллагаа төлөвлөснөөс Төрийн өмчийн компаниудын төсөв, санхүү, АМГТГ-ын кадастрын алба, тусгай зөвшөөрөл, ЗГ, Компанийн тайланг баталгаажуулахтай багц ажил, шаардлагатай сургалт, ҮЗ,АХ-ийн засаглал, 2020 он хүртэлх стратег боловсруулах зэрэг ажлуудыг оруулсан байна. Хоёрдугаар зорилгын хүрээнд 2016 оны тайланг ОУИТБС-ын стандартын чанартай сайн гаргахтай холбогдсон 8 ажил, гуравдугаар зорилгын орон нутаг дахь хэрэгжилтийг хангах, дэд зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх 9 нэрийн ажил, ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зураг төлөвлөгөөний 24 ажил, гэрээний ил тод байдлын чиглэлийн 7 ажил тус тус төлөвлөсөн байна. Санхүүжилтийн хувьд Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжинэ. Дэд зөвлөлийн санхүүжилтийг Засгийн газрын

2014 оны 43 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” ын дагуу БОАЖС-ын багцаас гаргах зөвлөмжийг Үндэсний зөвлөлөөс гаргахыг хүсье. Мөн ОҮИТБС нь гишүүний татвар болж байна. Одоогоор гишүүний татварыг жилийн 10,000 ам.доллараар тогтоож, холбогдох нэхэмжлэхийг ирүүлэх тул Үндэсний зөвлөлөөс зөвлөмж гаргахыг хүсье. /Танилцуулгыг хавсаргав/

Ж.Эрдэнэбат: Танилцуулгатай холбоотой асуулт байвал асууж болно.

Д.Эрдэнэчимэг: Гэрээний аргачлал боловсруулна гэсэн байна, энэ нь ямар гэрээтэй холбоотой вэ?

Ш.Цолмон: Энэ нь ажлын хэсгийн гишүүдээс авсан санал юм, аль болох бүх гэрээг хамруулах бодолтой, түүнийгээ тухай үедээ ярилцаад сонгох байх.

Д.Эрдэнэчимэг: Энэ нь ил тод байх талаасаа юу, агуулга талаасаа гэсэн үгүү?

Ш.Цолмон: Ил тод байх талаасаа

Н.Баярсайхан: Аудитын зөвлөмжид одоо байгаа мэдээлэл шаардлага хангахгүй байна, ТӨК-ууд тайлан гаргахгүй байна гэсэн байгаа. Эдгээр асуудлуудын хүрээнд хийгдэх ажлууд төлөвлөгөөнд тусгасан уу?

Ш.Цолмон: Эдгээртэй холбоотой ажлууд төлөвлөгөөнд тусгагдсан.

Ю.Дэлгэрмаа: Байгаль орчны шинэчлэн батлагдсан багц хуулинд байгаль орчны аудитыг 2 жилд нэг удаа хийхээр хуульчилсан байгаа. 2017 оны төлөвлөгөөнд байгаль орчны аудитыг хийлгэх талаар тусгасан уу?

Ш.Цолмон: Яг байгаль орчны аудитын талаар тусгайлан ажил оруулаагүй, харин БОАЖ яамнаас төлөвлөгөөний 2,4 дээр аж ахуйн нэгж бүрээр уул уурхайн зориулалтаар эвдэрсэн, нөхөн сэргээсэн мэдээллийг гаргах талаар санал тавьж, үүнийг төлөвлөгөөнд тусгасан.

Ю.Дэлгэрмаа: Нөхөн сэргээлтийн асуудал бол өөр хэрэг, манайд байгаль орчны аудит гэдэг бол шинэ зүйл юм гэхдээ энэ бол маш чухал асуудал. Иймээс хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор төлөвлөгөөнд нэмэлт байдлаар тусгах эсвэл зөвлөмж гаргах байдлаар асуудал болгохыг хүсэж байна.

Ш.Цолмон: За тэгье

Г.Батсайхан: Уул уурхай эрхлэгчдийн хариуцлага, хандив тусламжийг яаж зарцуулах сая асуудал яригдлаа. 2007 онд хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт, 8 зарчим батласан байгаа. Үүнийг стандарт болгох талаар хөөцөлдөж байна, одоо албажих хэрэгтэй байгаа. Үүний нэг зарчим нь ил тод байх асуудал юм, гарын авлага боловсруулаад дуусч байгаа, энэ талаар ажлын төлөвлөгөөнд тусгах боломжтой юу?

Н.Алгаа: ISO 26000 гэсэн стандарт байгаа, 2012 онд Ажил олгогч эздийн холбооноос орчуулаад Стандартчилал хэмжилзүйн газраар батлагдсан 170 гаруй хуудас компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх зөвлөмж гэсэн стандарт байгаа. Үүнийг сайн дураар хэрэгжүүлэх ёстой. Гагцхүү стандартыг сургах таниулах ажил байхгүй учраас хэрэгжүүлж чадахгүй байна. Манайд олон стандарт байдаг ч хэрэгждэггүй. Байгаль орчны аудит тусгай хуультай, хэрэгжүүлэх байгууллагатай. ОУИТБС нь олборлох салбарын татвар, төлбөр хураамжийн хэмжээнд явагдаж байсан, Олон улсын долоон стандартын дагуу явж байгаа. Иймээс нэг юм руу бүх юмыг чихдэг нь буруу гэдэг саналыг хэлмээр байна.

С.Энхтуяа: ОУИТБС-ийн 2013, 2014, 2015 оны тайлангийн зөвлөмжүүдээ нэгтгэсэн зөвлөмж гаргаж хэлэлцэх саналтай байна.

Г.Батсайхан: Нэг тодруулга хэлэхэд, компанийн нийгмийн хариуцлагын стандарт нь ерөнхий, хариуцлагатай уул уурхайн стандарт гэдэг нь уул уурхайд чиглэгдээд бичигдсэн стандарт юм.

Д.Эрдэнэчимэг: Аргачлал боловсруулахад зардал нь 300,000 төгрөг гэсэн байна, аргачлалыг хэвлэх юм болов уу? төсвөө эргэж харахгүй бол хэрэгжихгүй ажил болчихвий?

Ш.Цолмон: За, тэгье.

Н.Баярсайхан: 2016 оны ажил боломжийн хэмжээнд хэрэгжсэн гэж үзэж байна. Төлөвлөгөөний 2-р зорилго дээр “олон нийтэд мэдээлэх” гэдгээ 3-р зорилго руу тавиад, 2-р зорилго дотор байгаа бусад байнга хийгддэг тодорхой ажлуудыг нэгтгэж 258 сая дүнгээ нэг болгож гаргавал зүгээр, илүү ойлгомжтой болох байх, ингэж нарийвчилж урт хүснэгт харагдуулах шаардлагагүй байх гэсэн санал байна.

3. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зураг төлөвлөгөөний төслийн тухай.

Д.Дамба: Өнөөдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанд УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Нандинжаргал оролцож байна. Ашиг хүртэгч эздийг ил тод болгох ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын дэд хэсэг нь төр, компани, иргэний нийгмийн 16 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд 3 удаа хуралдаж, замын зургийн төслийг боловсруулсан. Ажлын хэсгийн хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн. Тухайлбал, ННФ-той хамтран эрхзүйн орчныг үнэлсэн судалгаа хийгдсэн, Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэнтэй хамтран ашиг хүртэгч эздийн ил тод байдлын талаар сургалтуудыг хийсэн. Мөн ашиг хүртэгч жинхэнэ эздийн ил тод байдлыг хангах чиглэлээр судалгааны ажил хийгдсэн. Маргааш буюу 12 сарын 21-ны өдөр хэлэлцүүлэг хийхээр бэлтгэсэн. Замын зургийн төслийг боловсруулж ажлын хэсгийн хуралдаанаар танилцуулсан бөгөөд хуралдаанаас гарсан гишүүдийн саналыг тусгаад өнөөдөр эцсийн байдлаар танилцуулж байна. Ажлын хэсгийн хүрээнд нийт 11 орны туршлагыг судалсан. Судалгааны дүнгээр хаалттай байсан асуудалд тодорхой хэмжээний ахиц өөрчлөлт

гарсан. Ойлголтын зөрүү үүсэх хүндрэлүүд гарч байсан, энэ нэгдсэн ойлголтод хүрч байгаа. Ашиг хүртэгч эздийг ил болгоход дээрх сургамжууд тодорхой туршлага болно гэж үзсэн. Монгол улсад ашиг хүртэгч эздийг ил болгох боломжтой юу гэдэг асуудлыг бид боломжтой гэж үзэж байна. Тухайлбал, Үндэсний бодлого стратегид тусгагдсан, бүрэн бус ч гэсэн институтын хүрээ бий болсон гэж үзэж байгаа. Замын зургийн төслийг 2020 он хүртэл боловсруулсан. Нийт 7 зорилт, 32 үйл ажиллагаа төлөвлөсөн. Төлөвлөгөөний гол зорилго бол эрдэс баялагийн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, тендерт оролцогч компаниудын ашиг хүртэгч буюу бенефициар өмчлөгчдийг ил болгосноор олон нийтийн зүгээс тавих хяналт сайжирч, эздийн хариуцлага нэмэгдэнэ гэж үзсэн. 2017 онд 5 зорилт бүхий ажил, 2018 онд олж авсан мэдээллээ баталгаажуулах, холбогдох журам маягтыг шинэчлэх ажлыг хийнэ. 2019 онд тайланг олон нийтэд ил болгох зорилтыг тавьж байна. /Танилцуулгыг хавсаргав/

Ж.Эрдэнэбат: За баярлалаа. Холбогдох асуулт байна уу? Одоо өнөөдрийн хуралдааны шийдвэрийн төслийг урьдчилан тараасан байгаа, шийдвэртэйгээ танилцаад, шийдвэрээ батлах уу?

Хуралдааны шийдвэрийн төслийг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Н.Энхбаяр уншиж танилцуулан, гишүүд 100 хувь дэмжиж батлав.

Ж.Эрдэнэбат: За өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон бүх гишүүдээ баярлалаа.

Хуралд 16,15 цагт өндөрлөв.

Хуралдааны шийдвэр:

Монгол Улсын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

I. **Хэлэлцсэн нь:** Монгол Улсын Улаанбаатар аудит корпорац, Их Британийн Харт Нойрс ХХК-ийн хамтарсан концерцумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны буюу 10 дугаар нэгтгэл тайлан:

Шийдвэрлэсэн нь:

1. Монгол Улсын Улаанбаатар аудит корпорац, Их Британийн Харт Нойрс ХХК-ийн хамтарсан концерцумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны тайланг дэмжиж, хуралдаан дээр гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов.
2. Монгол Улсын 2015 оны тайланг оролцогч бүх талууд өөрсдийн цахим хуудаст байрлуулах, Ажлын албанаас хураангуй хувилбарыг нийтэд ил тод болгож, сурталчлах нь зүйтэй гэж үзэв.
3. Монгол Улсын 2015 оны тайлан, 2016 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2017 оны ажлын төлөвлөгөөтэй хамт ОУИТБС-ын олон улсын удирдах хороонд 2016 оны 12 дугаар сарын 31- ний дотор илгээхийг Ажлын албанд даалгав.
4. Энэхүү тайлан, Үндэсний зөвлөлийн хуралдааны талаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав.
5. Энэхүү тайлангаар заасан зөвлөмж бүрээр дараах шийдвэрүүдийг гаргав.:

Зөвлөмж 1 - Үндэсний зөвлөлөөс нь энэ асуудлыг Уул уурхайн сайдад даалгаж, АМГТГ нь БХГ-үүдийг олон нийтэд ил болгох нь зүйтэй.- **Уул уурхай, хүнд**

үйлдвэрийн яаманд 2017 оны эхний хагаст багтаан зөвлөмжийн дагуу шийдвэрлэхийг даалгав.

Зөвлөмж 2- АМГТГ нь олон нийтэд ил тод болгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл нь ОУИТБС-ын Стандартын хамгийн наад захын шаардлагыг хангасан байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. *(энэ зөвлөмжийг өмнө жил бас өгсөн байсан)*- **Ашигт малтмал газрын тосны газарт 2017 оны эхний хагаст багтаан зөвлөмжийн дагуу шийдвэрлэхийг даалгав.**

Зөвлөмж 3- АМГТГ нь лицензийн талаарх тодруулж буй мэдээллээ зохистой эсэхийг нягталж үзэж, Ажлын хэсэг нь энэ асуудлын мөрөөр АМГТГ-т хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.- **Ашигт малтмал газрын тосны газарт 2017 оны эхний хагаст багтаан зөвлөмжийн дагуу шийдвэрлэхийг даалгав.**

Зөвлөмж 4- Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь БОАЖЯ- тай хамтран бүх олборлох үйлдвэрлэлийн ТӨААН-үүдийг нөхөн сэргээлтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулж, цаашдын санхүүгийн тайландаа нөхөн сэргээлтийн зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу тусгахыг зөвлөж байна.- **Эрдэнэс Монгол ХХК-д БОАЖЯ- тай хамтран 2017 оны эхний хагаст багтаан шийдвэрлэхийг даалгав.**

Зөвлөмж 5- Ажлын хэсэг нь аудитын тайланд өгсөн хязгаарлалтын талаар Сангийн яам болон ТӨААН-үүдтэй зөвшилцөж, санхүүгийн хяналтанд шаардлагатай сайжруулалтыг авч хэрэгжүүлэх төлөвлөгөө цаг хугацаа, боломж нөөц байгаа эсэхийг баталгаажуулахыг зөвлөж байна.-**Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, 2017 оны эхний хагаст багтаан шийдвэрлэхийг Ажлын албанд даалгав.**

Зөвлөмж 6- ОУИТБС-ын Засгийн газрын тайлагналын баталгаажуулалтыг сайжруулахын тулд Ажлын хэсэг нь МҮАГ-тай хамтран ажиллахыг зөвлөж байна. ҮАГ-ын ажлын төлөвлөгөөнд энэ ажлыг тусгуулсанаар ЗГ-ын ОУИТБС-д ирүүлсэн мэдээнд дүгнэлт өгөхөд шаардлагатай нөөц бололцоо болон цаг хугацаа бүрэлдэнэ. Дараагийн тайланд энэхүү асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд ҮАГ-ын 2017 оны ажлын төлөвлөгөө батлагдах гэж байгаа энэ үед нэн даруй ҮАГ-тай зөвшилцөх шаардлагатай. **-2018 оноос эхлэн үйл ажиллагааны төсөвтөө зардал хуваарилуулан, мөрдөж ажиллахыг Үндэсний аудитын газарт зөвлөмж болгов.**

Зөвлөмж 7- Эдгээр баталгаажуулалтын асуудлуудын нийцлийн түвшин чухал учир сайжруулах шаардлагатай. ОУИТБС-ын Ажлын алба нь дараагийн ОУИТБС-ын тайланд илүү сайн нийцлийг бий болгохын тулд компаниуд, ТӨААН болон Засгийн газрын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.-**Холбогдох талуудтай хамтран ажиллаж, 2017 оны эхний хагаст багтаан эргэн мэдээлэхийг Ажлын албанд даалгав.**

Зөвлөмж 8 - ОУИТБС-ын Ажлын алба нь дараагийн ОУИТБС-ын тайлангийн нийцлийг сайжруулах үүднээс компаниуд, ТӨААН болон Засгийн газартай хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Ажлын хэсэг нь үл нийцэх асуудал гарвал зөвшөөрөл авах механизмыг харгалзан үзэх шаардлагатай. **Холбогдох талуудтай хамтран ажиллаж, 2017 оны эхний хагаст багтаан эргэн мэдээлэхийг Ажлын албанд даалгав.**

Зөвлөмж 9- ОУИТБС-ийн ОТАХ нь ОУИТБС-ын тайлан бүрийн өмнө цахим тайлагналын системийг ашиглан тухайн компаниудыг олборлох үйлдвэрлэлийн компани мөн эсэхийг урьдчилан шалгаж байхыг зөвлөж байна **-2016 оны нэгтгэл тайлангийн 2017 оны эхний хагаст багтаан эргэн мэдээлэхийг Ажлын албанд даалгав.**

Зөвлөмж: 10- МОУИТБС-ийн цахим тайлангийн системийг гүйцэтгэгчээс бүрэн хүлээн авахдаа сонгон шалгаруулалтын материалд заагдсан шаардлагын дагуу дараах байдлаар хүлээн авах. Үүнд:

- Системийг нөөц хувилбартайгаар хүлээн авах

- Системийн хэвийн ажиллагаанд шаардлагатай гарын авлагуудыг хүлээн авах (тухайлбал: Үйлдлийн систем суулгах, түүнд шаардлагатай аюулгүй байдлын тохиргоонуудыг хийх, нөөц хувилбарын тохируулах, өгөгдлийн санг суурилуулах гарын авлага)
- Системд цаашдын хөгжүүлэлтэд шаардлагатай эх кодыг авах
- Системийг дотроос болон гаднаас penetration test болон stress test хийлгэн хүлээн авах

Цахим системийн аюулгүй байдлын хувьд

- Системийг SSL сертификат бүхий хандалттай болгох
- Цахим тайлангийн системийн үйлдлийн системийн шинэчлэлийг (update) байнга хийх
- Системд зөвхөн админ эрх бүхий хэрэглэгчийн хандах ip хаяг болон ямар портоор хандалтыг тохируулах ба бусад шаардлагагүй портыг хаах
- Цахим тайлангийн системийн хандалтын болон халдлагын шинжтэй мэдээллийг илрүүлэх болон таслан зогсоох системд хамруулах

Системийн үйл ажиллагааны зохистой байдлыг сайжруулах талаар

- Цахим тайлангийн системд хандах хэрэглэгчдийн эрх, үүргийг нарийвчлах журамд тусгах
- Цахим тайлангийн системийг байрлуулах компанитай байгуулах гэрээнд тус системд зайлшгүй байх шаардлагатай аюулгүй байдал, нөөц хувилбар, өгөгдлийн санг хуулбарлах хамгаалах, ачааллыг хуваарилах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах талаар нарийн тусгах- **Эдгээр зөвлөмжүүдийг судлан үзэж 2017 оны эхний хагаст багтаан эргэн мэдээлэхийг Ажлын албанд даалгав.**

Зөвлөмж 11 - Хараат бус нэгтгэгч нь тайлангийн бэлтгэлд орох орцыг ирүүлэхийн тулд аль болох эрт сонгогдож, үйл явцад хамрагдах ёстой. Хараат бус нэгтгэгч нь цахим тайлагналын системийн агуулгын талаар шийдвэр гаргахаас өмнө 1 сарын сүүлээр хамруулах ёстой. –**Ажлын албанд даалгав.**

6. Хуралдаан дээр гишүүдээс гаргасан саналын дагуу:

- Бүх төрийн өмчийн компаниудад ОУИТБС-ын тайландаа тухайн жилийн санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг хавсаргах, нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэхийг үүрэг болгов.
- Тусгай зөвшөөрөл, төсөл бүрээр тайлагнах боломжийг нэмэгдүүлэх үүднээс тусгай зөвшөөрөл бүрээр зардлыг хаших боломжийг судалж, 2017 оны эхний хагаст эргэж мэдээлэхийг АМГТГ-д даалгав.
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай дансны орлого буцаан олголтын мэдээллийг сүүлийн 5 жил тус бүрээр гаргаж, Үндэсний зөвлөлд 2017 оны 1 дүгээр улиралд багтаан мэдээлэхийг БОАЖЯ-д даалгав.
- 2015 оны тайлангаар гарсан зөвлөмжүүдийг дахин нягтлаж эцэслэхийг Улаанбаатар аудит корпорацид санал болгов.
- 2014-2015 оны тайлангуудаар гарсан бүх зөвлөмжүүдийг судлаж нэгдсэн зөвлөмж гаргаж хэлэлцүүлэхийг Ажлын албанд даалгав.

f. Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ISO MNS 26000:2012 стандартыг олон нийтэд таниулах ажлыг идэвхжүүлэх, холбогдох сургалтуудыг зохион байгуулахыг Ажлын албанд даалгав.

II. Хэлэлцсэн нь: Монголын ОУИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тухай

Шийдвэрлэсэн нь:

1. Монголын ОУИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлттэй танилцав.
2. Хийгдээгүй ажлуудыг 2017 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, явцыг Ажлын хэсэгт тухай бүр мэдээлж байхыг Ажлын албанд даалгав.

III. Хэлэлцсэн нь: Монголын ОУИТБС-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай

Шийдвэрлэсэн нь:

1. Монголын ОУИТБС-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусган батлав.
2. Төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэгт даалгав.
3. Монгол Улсын ОУИТБС-ын гишүүний татвар, Дэд зөвлөлийн санхүүжилтыг БОАЖС-ын багцаас гаргах асуудлыг судалж, албан хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг Ажлын албанд даалгав.

IV. Хэлэлцсэн нь: Монголын ОУИТБС-ын өгөгдөлийн мэдээллийн нээлттэй байдлын журам, бодлогын тухай

Шийдвэрлэсэн нь:

1. Монголын ОУИТБС-ын өгөгдлийн мэдээллийн нээлттэй байдлын бодлогыг батлахаар тогтов.

V. Хэлэлцсэн нь: ОУИТБС-ын ашиг хүртэгч эздийг 2020 он гэхэд ил тод болгох замын зураг төлөвлөгөөний төслийн тухай

Шийдвэрлэсэн нь:

1. ОУИТБС-ын ашиг хүртэгч эздийг 2020 он гэхэд ил тод болгох замын зураг төлөвлөгөөний төслийг баталж, хэвлэн нийтэлж, хэрэгжилтийг улирал бүр тайлагнахыг Ажлын албанд даалгав.


Тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч

Хянасан: Ажлын албаны зохицуулагч

Тэмдэглэл бичсэн

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн



Н.Энхбаяр



Ш.Цолмон

А.Отгонтунгага